



**ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ,
АУДИТЫН АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ**

Дугаар № ҮАГ/АА-2018-36

Улаанбаатар хот

Энэхүү гэрээнд оролцогч талууд болох Захиалагч *Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газар* (цаашид “захиалагч” гэх), үйлчлүүлэгч *Мал хамгаалах сан* (цаашид “үйлчлүүлэгч” гэх), гүйцэтгэгч *“Релаэнс секюритик аудит” ХХК* (цаашид “гүйцэтгэгч” гэх) нь дараах зүйлийг харилцан тохиролцож энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) 2018 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр байгуулав.

1. Гүйцэтгэгч нь энэхүү гэрээ болон гэрээний салшгүй хэсэг болох Хавсралт № 1-д тодорхойлсон “Ажлын даалгавар болон үйлчилгээний цар хүрээ”-нд заасан зөвлөх үйлчилгээг (цаашид “үйлчилгээ” гэх) үзүүлэх үүрэгтэй.
2. Гүйцэтгэгч нь захиалагчаас шаардаж буй мэргэжлийн дадлага туршлага, ажиллах хүчин болон техникийн эх үүсвэртэй бөгөөд гэрээнд заасан нөхцөл, болзлын дагуу үйлчилгээг үзүүлэхийг хүлээн зөвшөөрсөн болно.
3. Захиалагч нь зөвлөх үйлчилгээний, аудитын ажил гүйцэтгэх дугаар гэрээний ажлыг (цаашид “ажил” гэх) **Тендерт санал болгосон үнэд багтаан** (цаашид “гэрээний үнэ” гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн Зөвлөхийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно. (10000000)
4. Дор дурдсан бичиг баримт нь гэрээний хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:
Гэрээний ерөнхий нөхцөл;
Гэрээний тусгай нөхцөл;

Хавсралт №1 Ажлын даалгавар, үйлчилгээний цар хүрээ
Хавсралт №2 Тайлан гаргах хуваарь
Хавсралт №3 Ажиллах хүчин-Туслан гүйцэтгэгч- Голлох мэргэжилтний ажлын хуваарь
Хавсралт №5 Захиалагчийн хүлээх үүрэг

Гэрээ нь энд дурдсан Зөвлөх үйлчилгээг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно.

5. Захиалагч болон гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг, хариуцлагыг хүлээнэ.
6. Төрийн аудитын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.”Нууц мэдээллийг зохих зөвшөөрөлгүй задруулсан буюу ашигласан төрийн аудитын байгууллагын ажилтанд уг мэдээллийг өгсөн байгууллагын ажилтантай адил арга хэмжээ авна”

гэсэн хуулийн заалт нь гэрээгээр ажил гүйцэтгэж буй аудитын хуулийн этгээд болон түүний ажилтнуудад адил үйлчилнэ.

7. Бүрэн эцэслээгүй тайлан болон дүгнэлтийг бусдад задруулах, хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэхийг хориглоно.

8. Төрийн аудитын болон үйлчлүүлэгч байгууллага, түүний ажилтнуудтай харьцах ёс зүйг чанд мөрдөж ажиллах, тэдгээрийн нэр хүндэд халдахгүй байх үүрэгтэй.

9. Зөвлөх нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үүрэг хариуцлагыг хүлээж байна.

10. Захиалагч нь гэрээний дагуу Зөвлөхийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг хариуцлага хүлээж байна.

11. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

**Үндэсний аудитын газрын Санхүүгийн
аудитын газрын захирал бөгөөд
тэргүүлэх аудитор**

 **Ц.НАРАНЧИМЭГ**

**Хаяг: Улаанбаатар-15160, Чингэлтэй
дүүрэг, Бага тойруу-3, Засгийн газрын
IV байр, 107 тоот
Утас: 261663**

ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

**Мал хамгаалах сангийн
Захирал**

 **Д. Пүрэвцэрэн**

**Хаяг: Хан-Уул дүүрэг, 3-р хороо,
Ажилчидын гудамж, ТЭЦ-3 баруун
тал ТЭДС байр.**

Утас: 77557771

**Үйлчлүүлэгчийн банкны дансны
дугаар: Төрийн сан: 100900019044
100900019303
100900019416**

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

**“Релаэнс секюритиз аудит” ХХК-ийн
Захирал**

 **Ж. ЦЭЦЭГМАА**

**Хаяг: Чингэлтэй дүүрэг, 9-р хороо, 7-р
хороолол, Компьютер малл центр, 7-р
давхар, 7024 тоот**

Утас: 99813174, 99087198

Факс :

Гүйцэтгэгчийн банкны дансны дугаар:

Голомт банк: 2105004706

ХХБ: 411026038